Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/45 дугаар захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааг дүгнэхэд тус сум нь 81,2 хувьтай, “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчид”-ийг дэмжих урианы жилийн хэрэгжилт 76,1 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянжаргалан сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд 2022 онд дотоод хяналт шалгалтыг төсөвт 6 байгууллагад улирал бүр хийж хэвшиж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан байна

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,768,523.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,950,670.3 мянган төгрөгөөр буюу 52,4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	243,092.04	318,214.39	75,122.35
Авлага	235,219.70	248,740.70	13,521.00
Бараа материал	225,158.81	163,047.89	-62,110.92
Үндсэн хөрөнгө	3,015,723.57	1,038,520.81	-1,977,202.76
Нийт хөрөнгө	3,719,194.12	1,768,523.79	-1,950,670.33
Өр төлбөр	24,584.71	21,967.49	-2,617.23
Засгийн газрын хуьт оролцоо /Эздийн өмч/	3,694,609.41	1,746,556.30	-1,948,053.11
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн	3,719,194.12	1,768,523.79	-1,950,670.33

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 318,214.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 75,122.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн орон нутгийн хөгжлийн сангийн эцсийн үлдэгдэл 110,039.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 60,193.1 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн эцсийн үлдэгдэл 48,238.8 мянган төгрөг болж өмнөх оноос 43,471.1 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 248,740.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,521.0 мянган төгрөгөөр өссөн нь сум хөгжүүлэх сангийн авлага 120,770.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 163,047.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,110.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд харьяа байгууллагууддаа санхүүгийн тайлангаа нэгтгэдэг болсноор Эрүүл мэндийн төвийн 47,929.6 мянган төгрөг, ЕБС-ийн 61,055.7 мянган төгрөг, Цэцэрлэгийн 29,264.7 мянган төгрөг, Соёлын төвийн 8,804.3 мянган төгрөгийн, нийт 147,054.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,038,520.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,977,202.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,567,598.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 1,746,556.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,948,053.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,238,591.1 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 318,214.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 75,122.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	243,092.04	318,214.39	75,122.35
Төгрөг	243,092.04	318,214.39	75,122.35
Төрийн сангийн харилцах	238,324.09	269,975.52	31,651.43
Арилжааны банк дахь харилцах	4,767.95	48,238.87	43,470.91
Дүн	243,092.04	318,214.39	75,122.35

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 318,214.4 мянган төгрөгийн 19,1 хувь буюу 60,938.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 34,5 хувь буюу 110,039.8 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 22,6 хувь буюу 72,022.3 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 8,4 хувь буюу 26,975.1 мянган төгрөгийг байгаль хамгаалах сангийн, 15,1 хувь буюу 48,238.8 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн дансны үлдэгдэл тус тус эзэлж байна. Арилжааны банканд эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл 48,238.8 мянган төгрөг байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 75,122.3 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн эцсийн үлдэгдэл 110,039.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 60,193.1 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн эцсийн үлдэгдэл 48,238.8 мянган төгрөг болж 43,471.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 248,740.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,521.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас санхүүжилтийн авлага	1,193.90	-	-1,193.90
Байгууллагаас авах авлага	35,415.50	18,919.50	-16,496.00
Хувь хүмүүсээс авах авлага	198,610.10	229,821.10	31,211.00
Дүн	235,219.50	248,740.60	13,521.10

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 248,740.6 мянган төгрөгийн 91,5 хувийг хувь буюу 227,551.1 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 163,047.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,110.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	68,489.38	15,829.38	-52,660.00
Тусгай зориулалтын материал	6,105.41	-	-6,105.41
Эм боох материал	62,383.96	15,829.38	-46,554.58
Хангамжийн материал	156,669.43	147,218.51	-9,450.92
Бичиг хэргийн материал	14,522.52	3,562.10	-10,960.42
Аж ахуйн материал	96,659.25	20,713.00	-75,946.26
Сэлбэг хэрэгсэл	2,488.00	114,268.23	111,780.23
Түлш, шатах тослох материал	1,824.34	-	-1,824.34
Хүнсний материал	7,916.06	-	-7,916.06
Бусад хангамжийн материал	31,389.25	6,805.19	-24,584.07
Мал амьтад	1,870.00	1,870.00	0.00
Нооцийн бараа			0.00
Дүн	225,158.81	163,047.89	-62,110.92

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 163,047.8 мянган төгрөгийн 15,964.8 мянган төгрөг буюу 9,8 хувийг эмийн эргэлтийн сан, 142,483.3 мянган төгрөг буюу 87,4 хувийг ЗДТГ, 4,599.6 мянган төгрөг буюу 2,8 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл 62,110.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 61,055.7 мянган төгрөг, Цэцэрлэгийн 29,264.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 47,929.6 мянган төгрөг, Соёлын төвийн 8,804.3 мянган төгрөг, нийт 147,054.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,038,520.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,977,202.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 1,638,309.2 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,4 хувь буюу 1,628,772.9 мянган төгрөгийг сумын ЗДТГ, үлдэх хувийг эмийн эргэлтийн сан, ИТХ, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,338,748.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 228,850.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 1,678,691.3 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 310,091.0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 433,029.8 мянган төгрөгийн, Соёлын төвийн 145,786.7 мянган төгрөгийн, нийт 2,567,598.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,823,135.91	1,553,207.23	-2,269,928.68
Барилга, байгууламж, орон сууц	3,148,292.77	1,294,876.98	-1,853,415.78
Авто тээврийн хэрэгсэл	130,813.26	154,677.35	23,864.09
Машин тоног төхөөрөмж	348,542.64	74,446.78	-274,095.87
Тавилга, аж ахуйн эд хогшил	171,747.11	29,206.13	-142,540.99
Бусад үндсэн хөрөнгө	8,386.88	-	-8,386.88
Номын фонд	15,353.26	-	-15,353.26
Биет бус хөрөнгө	153,922.00	85,102.00	-68,820.00
Программ хангамж	1,800.00	1,080.00	-720.00
Бусад биет бус хөрөнгө	152,122.00	84,022.00	-68,100.00
Дүн	3,977,057.91	1,638,309.23	-2,338,748.68

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 21,967.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,617.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,013.09	0.00	-5,013.09
Байгууллагад төлөх өглөг	19,571.62	21,967.49	2,395.86
Дүн	24,584.71	21,967.49	-2,617.23

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 2,617.2 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвийн байгууллагууд болох сургууль, соёлын төвийн өглөг шилжсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 21,967.4 мянган төгрөгийн үлдэгдлийн 12,768.6 мянган төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 4,148.8 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 4,650.0 мянган төгрөг нь байгаль хамгаалах сангийн өглөг эзэлж байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,746,556.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,948,053.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,948,053.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 800,582.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 728,876.6 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 1,557,907.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 1,976,501.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал / Засгийн газрын сан / орон нутгийн сан	1,523,630.48	723,048.42	-800,582.06
Хуримтлагдсан үр дүн	2,170,978.93	1,023,507.88	-1,147,471.05
Өмнөх үеийн үр дүн	1,158,011.86	2,715,918.98	1,557,907.12
Тайлант үеийн үр дүн	53,534.29	(1,922,967.28)	-1,976,501.57
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	959,432.78	230,556.18	-728,876.61
Дүн	3,694,609.41	1,746,556.30	-1,948,053.11

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баянжаргалан сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,231,945.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 198,614.8 мянган төгрөг, 2022 оны

төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,199,614.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 104,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 302,614.8 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 3,500.0 мянган төгрөгөөр бууруулан 788,886.7 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 121,000.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 407,228.1 мянган төгрөгөөр, нийт 1,317,114.8 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 04 дүгээр тогтоолоор баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч жил бүр орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэмж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 7,274.4 мянган төгрөгөөр бууруулан 294,340.4 мянган төгрөгөөр, нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 108,357.4 мянган төгрөгөөр бууруулан, шилжих үлдэгдлийн 2,962.6 мянган төгрөгөөр нэмж батлуулан 700,216.9 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 121,000.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 407,228.1 мянган төгрөгөөр, нийт 1,228,445.0 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2022 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол батлах тухай” 24 дүгээр тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 294,340.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 441,913.9 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 277,381.4 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 89,846.7 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 2,962.6 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 121,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 653,631.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 6,949.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 984,870.4 мянган төгрөг буюу 80,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 243,574.5 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт өгсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	54,476.5	50,477.2	3,999.2	92.6%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	378,361.9	358,528.2	19,833.6	94.7%
3	ЕБС-үйлчилгээ	125,632.0	124,530.4	1,101.5	99.1%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	37,466.6	35,418.2	2,048.3	94.5%
5	Соёл урлагийн үйлчилгээ	74,595.2	11,069.5	63,525.6	14.8%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	29,684.7	26,658.6	3,026.1	89.8%
7	Хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээ	407,228.1	257,188.2	150,039.8	63.1%
8	Хоршоо хөгжүүлэх сан	121,000.0	120,999.9	100	100%
	Нийт	1,228,445,0	984,870,4	243,574.5	80,1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв. түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 50,858.4 мянган төгрөг, ИТХ 300.0 мянган төгрөг, нийт 51,158.4 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого. зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/ мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 13 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 92,6 %	54,476.5	50,477.2
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 38 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 94,7%	378,361.9	358,528.2
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100%	121,000,0	120,999.9
			ХХС-аас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж 5 иргэнд зээл олгосон байна .		
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 7 зорилт 28 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022 онд “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ” сургуулийн дундаж 63%, Хөтөлбөрийн хэрэгжилт 90.3%, “	125,632.0	124,530.4
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 12 зорилт 42 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 94.5 %	37,466.6	35,418.2
6	71702- Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Соёлын төв нь 6 зорилт 32 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 87.3%	74,595.2	11,069.5

7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Нийт 8 төрлийн үзлэгт 1250 хүн, Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээнд 435 иргэдийг хамруулна.	Хөтөлбөрийн хэрэгжилт 89.8%	29,684.7	26,658.6
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 14 төслийг 407,228.1 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 6, мөнгийг нь дутуу шилжүүлсэн он дамжиж хийгдэх 1 ажил байна. 6 ажил хэрэгжээгүй Хэрэгжилт 63.1%	407,228.1	257188,2
Нийт дүн					1,228,445.0	984,870.4

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 05/39 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 2,881,474.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 43,222.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 32,416.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 52 мэдээлэл, мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 05/152 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	24,719.2	1	24,719.2	100%
Зөвлөмж	2	9,784.8	2	9,784.8	100%
Нийт дүн	3	35.504.0	3	35.504.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй ба нийт 93,939.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 524.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 93,415.0 мянган төгрөгийн зөрилд 1 албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах 1 зөвлөмжийг тус тус өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Оны эцэст нэмэлт санхүүжилтийн данснаас төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлэх ёстой 524.7 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Орон нутгийн орлогыг 7 нэр төрлөөр, нийт орлогын төлөвлөгөө 93,415.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 52 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС	1	17,568.0			1	17,568.0	1	17,568.0		
Дүн	1	17,568.0			1	17,568.0	1	17,568.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Засаг дарга	3	93,939.7	1	524.7	1	93,415.0	1	0.0		
ЗДТГ	5	45,052.7			3	32,350.7	2	12,702.0		
Дүн	8	138,882.4	1	524.7	4	125,765.7	3	12,702.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	0.0					1	0.0
ЭЭС	1	85,554.5					1	85,554.5
ОНХС	1	182,511.7					1	182,511.7
ХХС	1	53,497.8					1	53,497.8
Дүн	4	321,564.0					4	321,564.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	4	321,564.0					4	321,564.0